



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЯНЖАРГАЛАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 07

Аргатай

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2, 63 дугаар зүйлийн 63.1, Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, аймгийн засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01/329 дүгээр албан бичиг зэргийг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арван дөрөвдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь

1. Ашигт малтмал, газрын тосны газраас тус сумын нутаг дэвсгэрт 8018.81 га бүхий 10 дүрс бүхий талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох саналыг ирүүлсэнийг судлан үзэж сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арван дөрөвдүгээр хуралдаанаар хэлэлцэн хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 100 хувийн саналаар дээрх асуудлыг дэмжээгүйд тооцсугай.

2. Ашигт малтмал, газрын тосны газраас сонгон шалгаруулалтаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоор ялган ирүүлсэн 8081,81 га, 10 дүрс бүхий талбай нь түүх соёлын дурсгалт Шар гангын агуй, 3 булаг шанд, 7 малчин өрхийн өвөлжөө хаваржааны хороо бууц, ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Үнэн анд ХХК-ны уурхайн барилга байгууламжийн доорх газрууд зэрэгтэй давхцаж байгаа, дээрх талбайнуудаас 5 километр доторх нөлөөллийн бүсэд 56 малчин өрхийн 36000 малын бэлчээрийг хамарч байгаа, сумын нутаг дэвсгэрт ашиглалтын 32, хайгуулын 7, нийт 39 тусгай зөвшөөрөл байгаагаас тусгай зөвшөөрөлтэй 9 аж ахуйн нэгж нь нүүрс, жонш олборлох уул уурхайн үйл ажиллагааг байнгын явуулж буй тул нэмж ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгохыг эсэргүүцсэн 353 иргэний санал зэргийг үндэслэн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох боломжгүй гэж үзсүгэй.

3. Хуралдаанаас гарсан шйдвэрийг хууль тогтоомжид заасан хугацаанд багтааж аймгийн засаг даргад хүргүүлэхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (С.Баярхүү)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ЭРДЭНЭБАТ

